



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ  
ТОГТООЛ

2016 оны 01 сарын 13 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот


Тогтоолд нэмэлт, өөрчлөлт  
оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.9 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийг тус тус үндэслэн Хууль зүйн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Хууль зүйн байнгын хорооны 2015 оны 6 дугаар сарын 09-ний өдрийн 17 дугаар тогтоолын 1 дэх хэсэгт Улсын Их Хурлын гишүүн Ц.Оюунгэрэл, 2 дахь хэсгийн ажлын дэд хэсгийн бүрэлдэхүүнд Улсын дээд шүүхийн Эрүүгийн танхимын шүүгч Д.Ганзориг, Ч.Хосбаяр, Тагнуулын ерөнхий газрын Мөрдөн байцаах хэлтсийн орлогч дарга Г.Төмөрбаатар, Хууль зүйн яамны Эрх зүйн шинэчлэлийн бодлогын газрын мэргэжилтэн Н.Мөнхтуяа, Хууль зүйн байнгын хорооны зөвлөх Т.Оюунчимэг, Б.Хонгорзул нарыг тус тус нэмсүгэй.

2.Тогтоолын 2 дахь хэсгийн ажлын дэд хэсгийн бүрэлдэхүүнээс Улсын дээд шүүхийн Эрүүгийн танхимын шүүгч Б.Цогт, Хууль зүйн байнгын хорооны зөвлөх Г.Нямдэлгэр нарыг тус тус хассугай.

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА



Д.ГАНБАТ